

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

2013 оны аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, багийн үйл ажиллагааны үр дүнг тооцох, 2014 онд баримталж ажиллах бодлого зорилтоо тодорхойлох зорилгоор “Нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2014 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Сүхбаатар суманд 23, 24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж, 2014 оныг аймгийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх “Ээлтэй орчин их бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан Сумдын Засаг нарыг хот суурингийн дахин төлөвлөлт, бүтээн байгуулалтын туршлага судлах, арга зүйн сургалтанд хамрууллаа.

XVII-р жарны ялгуусан хэмээх модон морь жилийн сар шинийн баярт зориулсан "Сэлэнгэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдан авцгаая" үзэсгэлэн худалдааг аймгийн Засаг даргын Тамгын газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, МҮХАҮ-ийн танхимын Сэлэнгэ аймаг дахь салбартай хамтран 2014 оны 1 дүгээр сарын 22-23 өдрүүдэд Соёл, спорт, аялал жуулчлалын газарт зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаанд Цагааннуур, Шаамар, Баянгол, Жавхлант, Сүхбаатар, Баруунбүрэн, Алтанбулаг, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Ерөө, Орхонтуул, Сант сумдын 65 аж ахуйн нэгж, 35 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, 20 гаруй төрлийн бэлэг дурсгалын зүйлсээр оролцож 5,2 сая төгрөгийн борлуулалтыг хийлээ.

Сумдад хууль эрх зүйн сурталчилгааны ажил зохион байгуулахад нь дэмжлэг болгон нэгдсэн загвар бүхий “Иргэдийн эрх зүйн хөтөч” мэдээлэл сурталчилгааны самбарыг, сум, багийн Засаг дарга, төр, төсвийн байгууллагуудаас төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сурталчлах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах, түүнийгээ бүртгэж, тайлагнахад зориулсан “Хууль эрх зүйн ажил зохион байгуулах арга зүй” гарын авлага, “Эрх зүйн ажлын дэвтэр”-ийг тус тус олгож сум, байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглуулж эхлээд байна

Эрүүл мэндийн яамнаас 2014 оныг “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд С.Удвалыг Сэлэнгэ аймагт ажиллах үеэр аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг хамтран аймгийн эрүүл мэндийн салбарын ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт сум, тосгодын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Захирагч, эрүүл мэндийн төвүүдийн эрхлэгч нарыг хамрууллаа.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат аймгийн төв улсын тэргүүний ерөнхий боловсролын 4-р сургуулийн үйл ажиллагаатай танилцан, сургуулийн багш, сурагч, эцэг эх, тус байгууллагатай хамтран ажилладаг төсөл хөтөлбөрийн байгууллагуудын төлөөлөл оролцсон “Боловсролын шинэчлэл хамтын үйл ажиллагаа 2014” сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгууллаа.

УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат, Д.Эрдэнэбат нар 2013 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Сэлэнгэ аймагт ажиллаж, Гишүүд аймгийн төв Сүхбаатар хотод хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай танилцан, барилгын ажил зогссон ажлуудыг ямар шалтгаанаар зогссон, цаашид үргэлжлэх ямар нөхцөл боломж байгаа талаар нэг бүрчлэн танилцлаа.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

12-р сарын 30-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
-----	-------------	------------	-----------	------

1	Орон нутгийн төсвийн орлого	15340249.2	15385403.14	100.3
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	11702741.9	11713848.9	100.1
3	Орон нутгийн төсвийн зарлага	54389016.5	53454506.17	98.3
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	13587356.7	13274631.3	97.7
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2252593.0	2133580.0	94.7
	Авто замын хөрөнгө оруулалт	330750.0	302931.7	91.6
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3537300.0	3537300.0	100
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1616000.0	1471078.5	91.0
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	10205078.4	10205078.4	100.0
7	Засаг даргын нөөц	575000.0	530012.2	92.2

2013 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 100.3 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 94.7 хувь, тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 98.3 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 92.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 12-р сар	2014 оны 1-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	900	900
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	800, 1800	800, 1800
3	Нарийн боов	1 кг	1800-2300	1800-2300
4	Элсэн чихэр	1 кг	1800	1800
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	7000	8000
7	Үхрийн мах	1 кг	8000	9000
8	Адууны мах	1 кг	7000	7500
9	Ямааны мах	1 кг	6500	7000
10	Дотор мах цувдай	1 кг	3500	4000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	7500	8000
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	800	1100
13	Сүү /савласан/	1л	1700-1800	1700-1800
14	Тараг /задгай/	1л	1000	1200
15	Хорхой ааруул	1 кг	8000	8000

Аймгийн Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн ажил үйлчилгээг чанарын удирдлагын тогтолцоо, ISO 9001:2008 стандартад шилжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Өрхийн амжиргаа болон тогвортой амжиргаа-1, 2 төслийн 1997-2013 оны баримтуудыг хүлээн авч бүртгэл үйлдэн хөмрөгт байрлууллаа.

Тайлант сард Зэлтэр сангийн аж ахуйн 1959-1992 оны 268 хадгаламжийн нэгж, Зүүнхараа хотын Банкны хэлтсийн 1952-1995 оны 40 хадгаламжийн нэгжид тооллого хийж Зэлтэр сангийн аж ахуйн 1959-1973 оны 116 хадгаламжийн нэгж, Зүүнхараа хотын банкны конторын 1952, 1967 оны нийт 118 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

“Архив, албан хэрэг хөтлөлтөнд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Алтанбулаг сангийн аж ахуйн 19 хадгаламжийн нэгжийн 2666 хуудсыг photoshop програм ашиглан ашиглалтын хувь үүсгэн, Номгон сангийн аж ахуйн 1976-1990 оны 109 хадгаламжийн нэгжийн мэдээллийг AMS програмд шивлээ. Мастер хувь үүсгэх ажлын хүрээнд 3 хөмрөгийн 98 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж 11898 хуудас баримтыг сканердан мастер хувь үүсгэж, үдэж хавтаслан нүүрний бичилт бичиж хөмрөгт байрлууллаа.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 231, тодорхойлолт 42, магадлагаа 30, цалингийн тодорхойлолт 9 гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсролын чиглэлээр:

Боловсрол шинжлэх ухааны яамны үүсэн байгуулагдсаны 90 жилийн түүхт ойг 2014 оны 2 дугаар сарын 27-нд тэмдэглэх болсонтой холбогдуулан бүх шатны боловсролын байгууллагуудад “Бүтээлч үйлсийн аян”-ыг өрнүүлэн ажиллаж байна.

Аймгийн Боловсролын газраас Баруунбүрэн, Сант, Орхон суманд зөвлөн туслах чиглэлээр ажлын хэсгийг ажиллуулан “Сургуулийн өмнөх боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилт”-тэй танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн, цаашид авч хэрэгжүүлэх асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Аймгийн Боловсролын газар, Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран “Энгийнээр удирдахуй” сэдэвт сургалтыг 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж сургалтанд Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нийт 32 хүн хамрагдлаа.

“Эрүүл мэндийн боловсролыг олгоход хүүхэд нэг бүрийн хөгжилд тулгуурласан хүүхдээс хүүхдэд аргачлалыг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг Шаамар сум, Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, сургалтын менежер, захирлууд сургалтад хамрагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдыг дүрэмт хувцсаар хангах ажлыг бүсчлэн зохион байгуулан хангалт 66 хувьтай явж байна.

2. Эрүүл мэндийн талаар:

2014 оны 1 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд аймгийн Эрүүл мэндийн газар, Жайка олон улсын байгууллагатай хамтран сувилахуйн тусламж үйлчилгээнд “Зөвлөн туслах баг”-аар Хушаат сумын Эрүүл мэндийн төвд ажиллан тус сумын Сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор хяналт, шалгалт хийлээ.

“Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар 7 хоног бүрийн мягмар, баасан гаригт шуурхай зөвлөгөөн хийн эх, хүүхдийн эндэгдэл, дутуу төрөлт, амьгүй төрөлт, гэрийн төрөлтийг мэдээг хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

2014 оны 1 дүгээр сарын 4-5 ны өдрүүдэд Дулаанхан тосгонд аймгийн аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдааныг Цолтой бөхчүүд, Залуу бөхчүүд гэсэн ангилалаар зохион байгуулан нийт 32 бөх барилдлаа.

2014 оны 1 дүгээр сарын 11-12 ны өдрүүдэд Орхон суманд Монгол улсад шинэ үндсэн хууль батлагдсаны өдөрт зориулан үндэсний бөхийн барилдаан зохион байгуулж улс аймгийн цолтой нийт 32 бөх барилдсанаас

1-р байранд Увс аймгийн харъяат аймгийн заан Болдбаатар

2-р байр Дархан-уул аймгийн харъяат аймгийн арслан Ерөөлт

3-р байранд Хушаат сумын аймгийн начин Чинбат

4-р байранд Мандал сумын аймгийн начин Энхжаргал нар шөвгөрлөө.

3.Нийгмийн даатгалын талаар:

2014 оны 1 дүгээр сард Нийгмийн даатгалын сангуудад 1404622.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 1087955.5 мянган төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 77.5 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 19 нэгжээс 16 нь 1 тосгон нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 2.2-35.8 хувиар давуулан биелүүлж, 1 сум 30 хувиар төлөвлөгөөг тасаллаа.

Тэтгэврийн даатгалын сангаас 14714 тэтгэвэр авагчдад 1701506,1 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 55 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, оршуулганы зардалд 35916,5 мянган төгрөгийг зарцуулсан.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 323 тэтгэвэр авагчдын 62680.0 мянган төгрөгийн тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангаас 25 хүнд 20112.8 мянган төгрөгийн тэтгэмжийг олгоод байна.

Аймгийн 1 өөрийн хөрөнгийн үйлдвэрлэлийн үйлдвэрүүдэд Үйлдвэрлэлийн өвчний даатгалын сангаас 323 тэтгэвэр авагчдын 62680.0 мянган төгрөгийн тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангаас 25 хүнд 20112.8 мянган төгрөгийн тэтгэмжийг олгоод байна.

Аймгийн 1 өөрийн хөрөнгийн үйлдвэрүүдэд Үйлдвэрлэлийн өвчний даатгалын сангаас 323 тэтгэвэр авагчдын 62680.0 мянган төгрөгийн тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангаас 25 хүнд 20112.8 мянган төгрөгийн тэтгэмжийг олгоод байна.

3.Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 1420 иргэнд 278749.9 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 917 иргэнд 159768.2 мянган төгрөг, жирэмсэн, хөхүүл нярай 2650 эхэд 1271386.2 мянган төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 72216.2 мянган төгрөг, Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонтой 8539 эхэд 1173060.0 төгрөгийг тус тус олголоо.

Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд 2687 иргэнд 232479.8 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 58 иргэнд 102356.8 мянган төгрөг, Хүнс тэжээл хөтөлбөрт 2687 иргэнд нийт 228905.0 төгрөгийг олгоод байна.

Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан 2113 ахмад настанд хүндэтгэл үзүүлж сар шинийн бэлэг гардууллаа.

4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2013 оны 12-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 842 хүн байсан бол 38 иргэн шинээр бүртгүүлж ажилгүйчүүдийн тоо 880 боллоо.

эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалсан тухай улсын бүртгэлд бүртгэж аймгийн төрийн сангийн 130000941 тоот дансанд 180.000 төгрөгийг төвлөрүүллээ.

Газар өмчлөх эрхээ тухайн суманд хэрэгжүүлсэн эсэх лавлагааг нийт 7 иргэнд Алтанбулаг, Шаамар сум болон Дархан-Уул, Өмнөговь аймгуудад хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд 2012-2013 онд шинээр үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг мэдээллийн санд баяжилт хийн, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас, Татварын хэлтэст хүргүүллээ.

2. Байгаль орчны талаар:

Аймгийн Байгаль орчны газар 2013 онд Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн талаар сумдаас болон үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж тус бүрээс мэдээлэл авч нэгтгэн мэдээллийн бааз үүсгэлээ.

Сүхбаатар сумын “Цэнком” ХХК, Сайхан сумын “Дорнын зам” ХХК, Мандал сумын “Ноён тур” ХХК, Мандал сумын “Тайгын нарс” ХХК-ий ерөнхий үнэлгээний материалыг хүлээн авах ажлыг зохион байгууллаа.

Байгаль орчны газраас Өвөрхангай аймгийн “Тогосын нарс” ХХК-ээс шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

Долоо.Сум орон нутгийн талаар:

1.Баянгол сум:

Монгол Улсад Ардчилсан Үндсэн хууль батлагдсаны өдөрт зориулан тус сумын Засаг даргын Тамгын газраас шатарын тэмцээн, Хүчит бөхийн барилдаан, танин мэдэхүйн АХА тэмцээнүүдийг тус тус зохион байгууллаа.

Сумын хэмжээнд 55, 60-аас дээш насны ахмадуудыг “Ахмад настан нийгмийн хамгаалалын хууль”-ийн дагуу аж ахуйн нэгж байгууллагад дахин хуваарилалт хийж хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамнаас 2014 оныг “Гэр бүлийн хөгжлийн жил” болгон зарласантай холбогдуулан тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын Хараа, Баян, Гонир багийн нийгмийн ажилтануудтай хамтран зорилтот бүлгийн айл өрхүүдээр явж аж байдалтай танилцах, холбогдох хууль тогтоомжуудыг сурталчилах, тухайн өрхийн нөөц бололцоог судлах зорилгоор нийт 32 өрхөөр орлоо.

Хүний эрүүл, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор Баянгол сумын хүн малын ундны эх үүсвэр болох нийтийн эзэмшлийн худаг, уст цэгүүдээс усны дээж авч шинжилгээнд явуулах ажлыг зохион байгууллаа.

2.Баруунбүрэн сум:

Тус сум байгуулагдсаны түүхт 90-н жилийн ойн баярыг угтсан “Урлаг спорт-Бүтээлч ажил” сэдвийн дор 6 хэсгийн урлаг, спортын арга хэмжээг зохион байгууллаа.

Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэдэд мөнгөн урамшуулал олгох журмын дагуу нийт 1207 ширхэг баримтыг бүрдүүлэн аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

Тус сумын “Насан туршийн боловсрол олгох гэгээрэл төв” нь шүрний сургалт зохион байгуулж, Орхон аймгийн “Монгол дизайнер” төвтэй сургалт авахаар тохиролцон, хуримтлалын бүлгийн туршлага судалж 20 хүнд бүлгийн сургалт зохион байгууллаа.

2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн нэгдсэн эмнэлгийн ажлын хэсэг тус суманд ажиллаж “Эрүүл зан үйл Эрүүл амьдарлын үндэс” сэдэвт сургалтыг зохион байгуулж, иргэдэд үзлэг, оношлогоо хийлээ.

3.Ерөө сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв Ерөө сумын эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаатай танилцан, Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр худалдан авах эмийн тоо ширхэг, чанарын шаардлага, үнэ тарифанд хяналт шалгалт хийлээ.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2014 оны “Төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан Ерөө сумын эрүүл мэндийн төвөөс эмч, ажилчдын ёс зүй харилцаа, хандлага, эмчилгээ үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын баг, чанарын баг, ёс зүйн баг, аж ахуй үйлчилгээний багуудыг томилон үйл ажиллагаагаа сайжруулах арга хэмжээг зохион байгуулж байна.

4. Жавхлант сум:

2014 оныг Эрүүл мэндийн яамнаас “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан тус суманд нээлтийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв хамтран зохион байгууллаа.

XVII-р жарны ялгуусан хэмээх модон морь жилийн сар шинийн баярыг тохиолдуулан тус сумын Засаг даргын Тамгын газраас 70-аас дээш настны судалгааг гаргаж хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулан, мэндчилгээ дэвшүүлэх ажлыг зохион байгууллаа.

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулиас хүүхдийн хоол хүнсний хүрэлцээ, хангамж амт чанарын талаар эцэг эхчүүдэд сурталчлах, мэдээлэл өгөх зорилгоор “Эрүүл хоол, хүнс” сэдвээр 1 өдрийн амталгаат өдөрлөг зохион байгууллаа.

4.Зүүнбүрэн сум:

Тус сумын Засаг дарга иргэдэд хөнгөлөлттэй үнээр нүүрс нийлүүлэх зорилгоор “Ред Хилл Монголия” ХХК-тай гэрээ байгуулан 1 шуудай нүүрсийг 4000 төгрөгөөр борлуулж эхэллээ.

XVII-р жарны хөх модон морь жилийн цагаан сарын баярыг тохиолдуулан тус сумын Засаг даргын Тамгын газраас “Зүүнбүрэнд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой байдлын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагтай хамтран “Олон нийтийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдлийг бууруулах нь” сэдэвт сургалтыг орон нутагтаа зохион байгуулж төр төсвийн байгууллагуудын ажилтан, албан хаагч нар болон иргэдийг хамруулж, сургалтын үр дүнг бататгах зорилгоор сургалтанд хамрагдсан иргэдээр дасгал ажиллууллаа.

Монголын тулгар төр үзэсгэлэн гаргаж, үзэсгэлэнгээр дамжуулан Монголын төрийг барьж байсан хаадууд, Богд хаант Монгол улсын анхны сайд нар, төрийн далбаа, төрийн сүлд, есөн хөлт цагаан туг, төрийн тамганы талаарх мэдээллийг сумын нийт иргэдэд сурталчиллаа.

5.Орхон сум:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2014 оны 1 дүгээр сарын 20-ний өдөр Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд, төр төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт Монгол Улсын Хот байгуулалтын тухай хууль, Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, худалдан авах арга хэмжээний талаар мэдээлэл өгч сургалт зохион байгууллаа.

2015 онд халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 165.7 мян.тол, празит өвчин 148.5 мян.тол, лабораторийн шинжилгээнд 1295 мян.тол мал тус тус хамруулахаар захиалга өглөө.

Тайлант хугацаанд 2013 онд тус сумын Засаг даргын Тамгын газраас “Сум хөгжүүлэх сан”-аас зээл авсан нийт 41 зээлдэгчийн төслийн хэрэгжилт, зээлийн ашиглалтанд хяналт тавихаар сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн ажлын хэсэг газар дээр нь очиж үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилттэй танилцлаа.

6.Орхонтуул сум:

Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор тус сумын Засаг даргын Тамгын газраас “Мэдээллийг иргэн бүрт” арга хэмжээг зохион байгуулж, тайлант сарын 9, 13-ны өдрүүдэд 90 гаруй өрхөөр орж Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гарааны жилийн ажлын тайланг иргэдэд хүргэлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас нийтийн биеийн тамир спортыг түгээн дэлгэрүүлэх, Орхонтуул сумын Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газар, тус сумын ерөнхий боловсролын сургуультай хамтран Монгол Улсад Шинэ үндсэн хууль батлагдсаны өдрийг тохиолдуулан Үндсэн хууль теле хичээлд нийт суралцагчдыг хамруулахаас гадна Төрийн дууллаа хэн сайн дуулах, Үндсэн хуулиа хэн сайн мэдэх вэ? Аха тэмцээнүүдийг зохион байгууллаа.

7.Сант сум:

2014 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Сант сумын Засаг даргын Тамгын газраас “Цагаан сар 2014” үзсгэлэн худалдааг зохион байгуулж үзэсгэлэн худалдаанд “Агар заяа”, “Усан сээр”, “Бортголжин”, “Сэлэнгэ тоотоо” зэрэг хоршоо, иргэд нийт 6 төрлийн даршилсан бүтээгдэхүүн, 16 төрлийн цагаан идээ, талх, бууз, банш, торт зэрэг 26 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 1585,0 мянган төгрөгийн борлуулалт хийлээ.

2013 онд ургац алдсан үр тариа болон тосны ургамлын талбайн судалгааг гаргаж, судалгаагаар үр тариа 203 га, тосны ургамал 300 га талбайд ургац алдсан дүнтэй байна.

Эрүүл мэндийн яамнаас 2014 оныг “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан тус сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв хамтран нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжихэд бүх нийтийн оролцоо” сэдэвт зөвөлгөөн зохион байгууллаа.

8.Сайхан сум:

Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Үндсэн хуулийн агуулга, бүтэц, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, улмаар мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор тус сумын Засаг даргын ивээл дор 2014 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр сумын хэмжээнд мэдлэг сорих болон хөгжөөнт цэнгээнт тэмцээнүүд, мэтгэлцээн болон гар зургийн уралдуунуудыг тус тус зохион байгууллаа.

Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулиас гадаад хэлний баярыг амжилттай зохион байгуулж, нийт сурагчдад түгээмэл хэрэглэгддэг 5 хэлний мэндчилгээний үг зааж өгөн, ханын сонингийн уралдааныг зохион байгууллаа.

Аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран Спортын мастер Ч.Үнэнмөнхийн нэрэмжит аймгийн “Чөлөөт бөхийн өсвөрийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, нийт 15 сумын 201 хүүхэд оролцлоо.

Тус суманд зохион байгуулагдсан Таеквондогийн их наадмыг 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулан, нийт 8 аймгийн 300 тамирчид 5 төрлөөр хурд хүч авхаалж самбаагаа сорилоо.

9.Сүхбаатар сум:

Монгол улсын “Үндсэн хууль”-ийн өдрийг орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 2014 оны 01 дүгээр сарын 13-нд ахлах ангийн сурагчдад “Монгол улсын үндсэн хууль” сэдэвт хичээлийг орж нээлттэй хэлэлцүүлэг хийсэн бөгөөд TV5 телевизээр гарсан теле зохиомжийг сургуулиудын 10-11-р ангийн сурагчдад үзүүлж “Үндсэн хууль”-ийн ач холбогдол, түүний түүхэн үнэ цэнийг түгээн дэлгэрүүллээ.

“Гамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай” хууль тогтоомж, галын аюулгүй байдлын стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг гэр хорооллын айл өрхөд хангуулах, гал түймрийн гаралтыг бууруулах, иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж мэдлэг олгох, мэргэжлийн зааварчилгаа өгөх, галын аюулгүй байдлыг хангуулж, эмзэг байдлыг бууруулах зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2014 оны 1 дүгээр сарын 5-15-ны хооронд нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Сум хөгжүүлэх сан”-ийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан иргэдийг зориулалтын дагуу ашигласан эсэх, төсөлийг хэрхэн хэрэгжүүлсэн байдал, ажлын байр гаргасан эсэхэд танилцан 140 иргэд аж, ахуй нэгжээр зөвлөгөө мэдээлэл өгч, зориулалтын бусаар ашигласан иргэдэд цаашид авах арга хэмжээний талаар сануулах арга хэмжээ авч ажиллалаа.

10.Алтанбулаг сум:

Тус суманд тайлант сард шинээр төрсөн хүүхдийн тоо 9, Бүртгүүлсэн гэр бүлийн тоо 4, Нас барсан хүний тоо 2, шилжин явсан иргэдийн тоо 9, шилжин ирэн иргэдийн тоо 11, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдийн тоо 15, Монгол-Оросын улсын хилийг нэг удаа нэвтрэх эрхийн үнэмлэх олгосон иргэдийн тоо 4897 байна.

Тус сумын Засаг даргын тамгын газраас төр т⁰ ñâèéí áàéãóóëëàãóáüí дунд “Хээрийн цай” нөхөрсөг аялалыг амжилттай зохион байгууллаа.

Аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү” шатрын тэмцээнд тус сумын Ä.Äáí áààòàð ààãø òàé áàáòàì èð-èä î ðî ëïï æ4 àèò, 2 ì °í Æ, 1 õ¿ðýë ì áààèèéí ýçýä áí ёлоо.

11.Цагааннуур сум:

Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар 2013 онд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд амжилт гаргасан Улсын сайн малчин, Тэргүүний тариаланч хамт олон, Тэргүүний тариаланч нарыг шалгаруулсан бөгөөд 2013 онд газар тариалангийн салбарт гаргасан амжилтаараа “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор сумын “Товхон хан” ХХК, “Улсын тэргүүний тариаланч”-аар “Баяндулаан Уул” ХХК-ий механикжуулагч Б.Одмөнх нар тус тус шалгарлаа.

Монгол улсын “Үндсэн хууль”-ийн өдрийг орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан суманд 2014 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр сумын цолгүй бөхчүүдийн барилдааныг бүсийн хэмжээнд өсвөр нас буюу залуучууд гэсэн 2 насны ангилалаар зохион байгууллаа.

2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “REDHIL MONGOLIA” ХХК-ий нэрэмжит Сэлэнгэ бүсийн сумдын /Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн, Шаамар/ оюутны аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Тус сумыг өвөл цагийн соёл, хүмүүжил, урлаг спортын арга хэмжээний хүрээнд “Баянсэлэнгэ” ХХК-иас ивээн тэтгэн явуулсан ахмадын гар бөмбөгийн тэмцээн, “НИК, Шунхлай” ШТС-аас ивээн тэтгэсэн сумын аварга шалгаруулах Снукер биллярдын тэмцээн, спорт цогцолбороос ивээн тэтгэсэн бүсийн сумдын сурагчдын дунд Шатрын тэмцээн, “Шинэ бадрах” ХХК-ий нэрэмжит шилжин явах цомын төлөөх 4 төрлийн спортын тэмцээн, “Нарийн шүрэн” ХХК, “Шинэ нуур” ХХК-

иудаас ивээн тэтгэсэн Зохиолын дууны тэмцээнүүдийг тус тайлант сард тус тус зохион байгууллаа.

12..Хушаат сум:

Тус суманд 2014 онд “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын саналыг иргэдээс санал авч багцлан эрэмбэлж багийн ИНХ, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж 14 төрлийн ажилд 279.0 сая төгрөгийг зарцуулахаар батлуулж зураг төсөв болон бусад бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Эрүүл мэндийн яамнаас 2014 оныг “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан, аймгийн Эрүүл мэндийн газар, тус умын Засаг дарга, эрүүл мэндийн төв, төр төсвийн байгууллагууд хамтран зарласан жилийн нээлт, зөвлөгөөнийг 2014 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Үндэсний аюулгүй байдлын бодлогын асуудал, ажлын байран дахь аюулгүй орчин, Хүн Амын Орлогын Албан татварын хуулийн хөнгөлөлт, Нийгмийн Даатгалын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж, хялбаршуулсан гарын авлага бэлтгэн 80 гаруй иргэнд тараалаа.

13.Шаамар сум:

Газар эзэмших гэрээний хугацаа дууссан 5 иргэний гэрээг шинэчилсэн кадастрын зургаар дахин гэрээ хийж баталгаажуулан, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд хуучин эзэмшиж байсан газраа өмчлөх хүсэлт гаргасан 2 иргэнд 0.18 га газрыг засаг даргын захирамжаар 1800200 төгрөгийн үнэ бүхий газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүллээ.

Монгол Улсын Шинэ үндсэн хуулийг батлалцахад сум орон нутгаа төлөөлөн оролцож явсан сум орон нутгийг олон жил удирдан чиглүүлж ирсэн төрийн нийгмийн зүтгэлтэн Б.Сайнжаргал агсаны ар гэрийнхэнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг тус сумын нутгийн өөрөө удирдах байгууллагаас зохион байгууллаа.

Билгийн тооллын дагуу хаврын тэргүүн сар, цагаан сарын шинийн нэгнийг тохиолдуулан ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь татан буугдсан буюу дампуурсан, түүнчлэн өөр орон нутгаас шилжин ирсэн харьялах байгууллага, аж ахуйн нэгж нь байхгүй болсон 70 ахмад настанд сар шинийн хүндэтгэл үзүүлж гарын бэлэг өгөх ажлыг зохион байгууллаа.

14.Түшиг сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах 4411” арга хэмжээг 2014 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулж, төр, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нар 2013 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон 2014 онд хийж хэрэгжүүлэх томоохон ажил, арга хэмжээнүүдийн талаар иргэдэд мэдээлэл хийлээ.

Сумын Засаг даргын Тамгын газраас амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 20 өрхөд түлээний тусламж үзүүлэн, нийт 36 өрхөөс аж амьдралаа дээшлүүлэх, орлогоо хэрхэн нэмэгдүүлэх талаар, сумын удирдлагууд хэрхэн дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай байгаа эсэхэд санал хүсэлтийг хүлээн авлаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Түшиг суманд үйл ажиллагаа явуулж буй “Мойлт нуга” ХХК-ий мод бэлтгэлийн ажилтай танилцаж, бэлтгэсэн модонд хэмжилт хийн, ойн цэвэрлэгээ, отводын дагуу ажил хийгдэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийлээ.

Найм.Бусад ажлын талаар:

Онцгой байдлын газар:

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Төрийн ордон, засгийн газрын байрууд, улсын онц чухал объектууд, төрийн захиргааны байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамж”-ийн хүрээнд

хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хамрагдах байгууллагуудын судалгааг гарган хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд гарсан аюулт үзэгдлийн судалгааг нэгтгэж, хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.

“Орон сууцны барилгын нэг болон зоорийн давхарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагад” гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төвөлөгөөт бус шалгалтын удирдамж, “Гэр хорооллын пийшин, зуух, яндангийн галын аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээний удирдамжуудын хүрээнд 99 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 251 зөрчил илрүүлж, 7 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгуулж, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 61, мэдэгдэл 23, танилцуулга 1, ажиллагаа зогсоох тогтоол 1, дүгнэлт 28 гал түймэр гарсан тухай акт 4, зөрчлийн тэмдэглэл 4, шинжээчийн дүгнэлт 1-ийг үйлдэж байгууллагын удирдлагад өгч, хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 2 аж ахуйн нэгж, байгууллагыг 300.000 төгрөгөөр, 1 албан тушаалтанг 60.000 төгрөгөөр торгож нийт 360.000 төгрөгийн захиргааны арга хэмжээ ногдуулсан.

2014 оны 1 дүгээр сард 14 удаагийн объектын гал түймэр гарсанаас 3 гал түймэр мэдээллээр ирж, гал түймрийн улмаас нийт 12189.0 мянган төгрөгийн хохирол учирлаа.

Аврах, гал унтраах ангиуд нийт 11 удаагийн объектын гал түймрийн дуудлагаар ажиллаж, 2 гал түймрийг иргэд унтрааж, 1 гал түймэр өөрөө унтарч, 1 тасгийн хүчээр 11 гал түймрийг 30.9 тонн ус, 263.4 литр шатахуун зарцуулан унтрааж, гал түймрийн аюулаас аж ахуйн нэгж, байгууллагын 123 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгааллаа.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

10 сумын 16 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийснээс 9 сумын 12 худалдаа үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олголоо.

Түшиг, Сүхбаатар, Мандал сумын 7 аж ахуйн нэгж, иргэний 6 нэрийн 10 хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулж, лабораторийн сорилт шинжилгээг үндэслэн баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргалаа. “Алтан тариа” ХХК-ий экспортлож байгаа 16 удаагийн 660 тн Буудайн хивэгийн тээвэрлэлтэнд баталгаа гаргаж, тохирлын гэрчилгээ олголоо.

Худалдаа үйлчилгээний 3 байгууллага, аж ахуй нэгж, иргэнд арга зүйн зөвлөгөө өгч, 5 нэрийн стандартаар хангах үйлчилгээ үзүүллээ.

“Гурван Мэргэд” хүнсний зах дээр ажиллаж худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 37 жин, 19 туухай баталгаажууллаа.

Цахилгааны 1 фазын 27 механик тоолуурыг ээлжит бус баталгаажуулалтанд хамрууллаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР